



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/16

Модот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засагзахиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.4, 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Орон нутгийн чанартай 3,1 км замын засвар, Гэр хорооллын шороон замыг тэгшлэх, засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга Б.Ганзориг - Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга Д.Өсөхгэрэл - Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хяналтын улсын байцаагч

Гишүүд О.Батбаяр - Төрийн сан, төлбөр тооцооны мэргэжилтэн

Э.Баяржаргал - Иргэн

Г.Золбоо - Ерөнхий боловсролын сургуулийн нярав

2.Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулж зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хугацаанд нь хүргүүлж ажиллахыг үнэлгээний хороо дарга (Б.Ганзориг) –д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ

